

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/123-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: Д.Чулуунцэцэг Утас: 7036-2442 Цахим хаяг: Chuluuntsetsegd@audit.gov.mn
---	--

Энэхүү тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
4. Аудитын тайлан	14-17
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
ДАРГА Т.ОДСҮРЭН ТАНАА

2024.2.23 № СЭА-2024/123-НАСТА-1043
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь тайлант онд орон тоо дутуу ажилласнаас шалтгаалан цалин НДШ-ийн зардлыг 70,939.9 мянган төгрөгөөр буюу 35.0 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

2023 онд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитад нийт 56 байгууллагыг хамруулахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 36 байгууллага буюу 64.3 хувийг хамруулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 82.4 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,676,597.37	4,268,700.00
33	АВЛАГА	45,597.37	304,700.00
335	Бусад авлага	45,597.37	304,700.00
3351	Байгууллагаас авах авлага	45,597.37	304,700.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,631,000.00	3,964,000.00
354	Хангамжийн материал	1,631,000.00	3,964,000.00
35410	Бичиг хэргийн материал	00.00	518,000.00
35420	Аж ахуйн материал	1,586,000.00	1,616,000.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	280,000.00
35470	Бусад хангамжийн материал	45,000.00	1,550,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	15,748,518.46	24,743,325.08
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,748,518.46	24,743,325.08
392	Биет хөрөнгө	15,579,851.88	24,743,325.08
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	20,077,900.00	31,798,900.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-11,229,274.92	-16,069,241.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,775,600.00	14,100,600.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,044,373.20	-5,086,933.44
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-711,333.42	-880,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	17,425,115.83	29,012,025.08
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	17,425,115.83	29,012,025.08
51	Засгийн газрын хувь оролцоо	17,425,115.83	29,012,025.08
512	Хуримтлагдсан үр дүн	17,425,115.83	29,012,025.08
51210	Өмнөх үеийн үр дүн	17,425,115.83	17,425,115.83
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	11,586,909.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	17,425,115.83	29,012,025.08

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	186,897,900.61	170,557,140.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	20,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	20,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	20,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	20,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	186,897,900.61	170,537,140.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	186,897,900.61	170,537,140.50
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	186,897,900.61	170,537,140.50
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	186,040,087.87	158,970,231.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	186,040,087.87	158,970,231.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	146,398,387.87	157,970,231.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	96,891,323.16	117,455,838.48
210101	Үндсэн цалин	69,970,093.18	77,912,935.96
210102	Нэмэгдэл	17,814,329.57	29,519,811.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,469,604.79	4,812,857.14
210104	Урамшуулал	3,637,295.62	5,210,233.44
2102	Ажил олгогчоос төлөх НДШ	12,166,854.29	14,807,049.39
210201	Тэтгэврийн даатгал	9,006,692.53	10,039,584.04
210202	Тэтгэмжийн даатгал	807,621.25	1,164,224.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	650,020.33	830,969.48
210204	Ажилгүйдлийн даатгал	162,505.14	208,293.66
210205	Эрүүл мэндийн даатгал	1,540,015.04	2,563,978.14
2104	Хангамж, бараа материалын зардал	18,734,700.00	9,670,750.00
210401	Бичиг хэрэг	4,497,000.00	2,753,220.00
210402	Тээвэр, шатахуун	5,871,800.00	4,140,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,129,900.00	1,933,420.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,822,600.00	844,110.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,766,300.00	153,500.00
210604	Урсгал засвар	5,226,900.00	153,500.00
2107	Томилолт, зочны зардал	9,328,000.00	7,487,400.00
210702	Дотоод албан томилолт	9,328,000.00	7,487,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн АҮ	895,000.00	904,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн АҮ	00.00	300,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	895,000.00	604,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,616,210.42	7,491,193.38
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	630,000.00	1,440,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,986,210.42	6,051,193.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,641,700.00	1,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,641,700.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	450,000.00	1,000,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	857,812.74	11,586,909.25
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	857,812.74	11,586,909.25

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	186,897,900.61	170,537,140.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	186,897,900.61	170,537,140.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	186,897,900.61	170,537,140.50
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	186,897,900.61	170,537,140.50
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	186,897,900.61	155,491,140.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	186,897,900.61	155,491,140.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	147,256,200.61	154,491,140.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	96,891,323.16	117,410,241.11
210101	Үндсэн цалин	69,970,093.18	77,867,338.59
210102	Нэмэгдэл	17,814,329.57	29,519,811.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,469,604.79	4,812,857.14
210104	Урамшуулал	3,637,295.62	5,210,233.44
2102	Ажил олгогчоос НДШ	12,087,977.45	14,807,049.39
210201	Тэтгэврийн даатгал	8,877,314.15	10,039,584.04
210202	Тэтгэмжийн даатгал	773,087.00	1,164,224.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	650,020.33	830,969.48
210204	Ажилгүйдлийн даатгал	162,505.14	208,293.66
210205	Эрүүл мэндийн даатгал	1,625,050.83	2,563,978.14
2104	Хангамж, бараа материалын зардал	17,737,700.00	12,128,450.00
210401	Бичиг хэрэг	4,497,000.00	3,271,220.00
210402	Тээвэр, шатахуун	5,871,800.00	4,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,129,900.00	2,238,120.00
210406	БҮТЭЭ	5,239,000.00	2,219,110.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,686,200.00	313,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,919,900.00	160,000.00
210604	Урсгал засвар	5,226,900.00	153,500.00
2107	Томилолт, зочны зардал	9,328,000.00	7,487,400.00
210702	Дотоод албан томилолт	9,328,000.00	7,487,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	895,000.00	904,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн АҮ хураамж	00.00	300,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	895,000.00	604,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	630,000.00	1,440,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	630,000.00	1,440,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,641,700.00	1,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,641,700.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	450,000.00	1,000,000.00
3	ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	15,046,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН	00.00	15,046,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	15,046,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	15,046,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	-15,046,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,159,208.18	00.00	16,159,208.18
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,159,208.18	00.00	16,159,208.18
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	408,094.91	00.00	408,094.91
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,425,115.83	00.00	17,425,115.83
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,425,115.83	00.00	17,425,115.83
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	17,425,115.83	00.00	17,425,115.83
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	11,586,909.25	00.00	11,586,909.25
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	29,012,025.08	00.00	29,012,025.08

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	255,058,800.00	170,537,140.50	84,521,659.5	66.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	255,058,800.00	170,537,140.50	84,521,659.5	66.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	254,058,800.00	169,537,140.50	84,521,659.5	66.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	180,584,200.00	117,410,241.11	63,173,958.9	65.0
210101	Үндсэн цалин	90,372,500.00	77,867,338.59	12,505,161.4	86.2
210102	Нэмэгдэл	66,376,400.00	29,519,811.94	36,856,588.1	44.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,114,500.00	4,812,857.14	6,301,642.9	43.3
210104	Урамшуулал	12,720,800.00	5,210,233.44	7,510,566.6	41.0
2102	Ажил олгогчоос НДШ	22,573,100.00	14,807,049.39	7,766,050.6	65.6
210201	Тэтгэврийн даатгал	13,757,100.00	10,039,584.04	3,717,516.0	73.0
210202	Тэтгэмж даатгал	2,204,000.00	1,164,224.07	1,039,775.9	52.8
210203	ҮОМШӨ-н даатгал	1,763,200.00	830,969.48	932,230.5	47.1
210204	Ажилгүйдлийн даат	440,800.00	208,293.66	232,506.3	47.3
210205	ЭМ даатгал	4,408,000.00	2,563,978.14	1,844,021.9	58.2
2104	Хангамж, бараа материалын зардал	14,331,500.00	12,211,450.00	2,120,050.0	85.2
210401	Бичиг хэрэг	4,560,000.00	3,271,220.00	1,288,780.0	71.7
210402	Тээвэр, шатахуун	3,900,000.00	4,400,000.00	-500,000.0	112.8
210403	Шуудан, холбоо,	2,160,000.00	2,238,120.00	-78,120.0	103.6
210406	БҮТЭЗ	3,711,500.00	2,302,110.00	1,409,390.0	62.0
2106	Эд хогшил, урсгал	24,335,700.00	15,276,500.00	9,059,200.0	62.8
210601	Багаж, техник,	20,428,700.00	11,798,000.00	8,630,700.0	57.8
210602	Тавилга	3,407,000.00	3,325,000.00	82,000.0	97.6
210604	Урсгал засвар	500,000.00	153,500.00	346,500.0	30.7
2107	Томилолтын зардал	8,634,300.00	7,487,400.00	1,146,900.0	86.7
210702	Дотоод албан том	8,634,300.00	7,487,400.00	1,146,900.0	86.7
2108	БГАҮХ	2,100,000.00	904,500.00	1,195,500.0	43.1
210801	БГАҮХ	500,000.00	300,000.00	200,000.0	60.0
210806	Мэдээлэл, үйлчил	1,600,000.00	604,500.00	995,500.0	37.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1500000.00	1440000.00	60,000.0	96.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	1,500,000.00	1,440,000.00	60,000.0	96.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	1,000,000.00	0.0	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,000,000.00	0.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	0.0	100.0
	САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	255,058,800.00	170,537,140.50	84,521,659.5	66.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС	255,058,800.00	170,537,140.50	84,521,659.5	66.9
132001	Орон нутгийн төсвөөс	255,058,800.00	170,537,140.50	84,521,659.5	66.9
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	07.00	06.00	1.0	
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.0	
620002	Гүйцэтгэх ажилтан	05.00	04.00	1.0	
620003	Үйлчлэх ажилтан	01.00	01.00	0.0	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь “Төсвийн сахилга батыг сайжруулах зорилгоор санхүүгийн хяналтын үр нөлөөг дээшлүүлж, эрсдэлийн удирдлагаар хангаж ажиллана” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны А/75 дугаар захирамжаар баталсан “Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дүрэм”-ийн 5.1-д тус албаны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төсөв, санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж дүрэм, журам, стандарт, гэрээг мөрдөж байгаа байдалд хяналт шалгалт, аудит хийх,
- Төсвийн хөрөнгийн зүй зохистой, үр ашигтай зарцуулалтад аудит хийх,
- Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалтад аудит хийх,
- Төрийн сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, аудит хийх,
- Нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв, найдвартай байдалд аудит хийх,
- Санхүүгийн мэдээллийн үнэн зөв, найдвартай байдалд хяналт шалгалт, аудит хийх,
- Хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалт, өмчлөлийн байдалд аудит хийх,
- Байгууллагын дотоод хяналтын болон засаглал, эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр ашигтай байдалд аудит хийх,
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр тусгайлсан аудит хийх,
- Холбогдох стандартын хүрээнд тодорхойлсон бусад аудит хийх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Монгол улсын засгийн газрын 2023 оны 06 сарын 21 өдрийн 241 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Сангийн сайдын 2023 онд хийгдэх “Дотоод аудитын чанарын үнэлгээ хийх ажлын хуваарь удирдамж”-ийн дагуу Санхүүгийн хяналт, шалгалт эрсдэлийн удирдлагын газраас 09 дүгээр сард тус албаны 2021-2022 онд хийгдсэн санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны аудитын үйл ажиллагаанд чанарын үнэлгээ хийсэн боловч хяналт шалгалтын тайлан, үр дүнг тайлагнаж, танилцуулаагүй байна.

Мөн аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн “Аудитын зөвлөмжийн мөрөөр зөвлөн туслах ажлын удирдамж”-ийн дагуу аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсээс Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийгдсэн байна.

Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсээс сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсвийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажил байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагууд “Сэлэнгэ аймгийн төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 29,012.0 мянган төгрөг болж өмнөх оноос 11,586.9 мянган төгрөгөөр буюу 66.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	45.6	304.7	259.1
Бараа материал	1,631.0	3,964.0	2,333.0
Үндсэн хөрөнгө	15,748.5	24,743.3	8,994.8
Нийт хөрөнгө	17,425.1	29,012.0	11,586.9
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	17,425.1	29,012.0	11,586.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	17,425.1	29,012.0	11,586.9

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

Авлага дансны үлдэгдэл 304.7 мянган төгрөг болж 259.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд НДШ-ийн 45.6 мянган төгрөгийг барагдуулж, интернэтийн үйлчилгээний 304.7 мянган төгрөгийн авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 3,964.0 мянган төгрөг болж 2,333.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 1,535.0 мянган төгрөгийн хангамжийн материал, 518.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 280.0 мянган төгрөгийн шатахууны үлдэгдэлтэй тайлагнагдсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 24,743.3 мянган төгрөг болж 8,994.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 11,721.0 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, 3,325.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил зэрэг нийт 15,046.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч бүртгэсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 174,996.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг нийт 80,062.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн **255.058.8** мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 73,414.0 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 6,648.8 мянган төгрөгөөр,

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр **255,058.8** мянган төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 170,537.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **170,537.1** мянган төгрөг буюу 66.9 хувьтай тайлагнагдаж, **84,521.6** мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 63,173.9 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 7,766.0 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 2,180.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 9,059.2 мянган төгрөгөөр, албан томилолтын зардлыг 1,146.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлыг 1,195.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	255,058.8	170,537.2	84,521.6	66.9
	Нийт	255,058.8	170,537.2	84,521.6	66.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус албаны нэмэлт санхүүжилтийн 100130051416 тоот дансанд тайлант онд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Чулуунцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 186,040.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,860.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга,

нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны мэдээлбэл зохих 20 төрлийн 158 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 1,088.6 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, 10,838.6 мянган төгрөгийн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлэн, 2,221.9 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,088.6	1	1,088.6	100
Албан шаардлага	6	10,838.6	4	10,838.6	100
Зөвлөмж	2	2,221.9	2	2,221.9	100
Нийт дүн	9	14,149.1	9	14,149.1	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой залруулсан алдаа гараагүй болно.

Аудитаар нийт 529.7 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 529.7 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэв.

5.1 Албан шаардлага

1. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас Юнивишн ХХК-иас интернэтийн төлбөрийн 304.7 мянган төгрөгийг авлага үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь *"Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *"Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах "* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

2. Нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлын батлагдсан төсвөөс эмнэлгийн тусламж үйлчилгээний зориулалттай 225.0 мянган төгрөгийн / *сахрын аппарат, тест, зүү, даралтын аппарат*/ бараа материалыг худалдан авч, төсвийг зориулалт бусаар зарцуулсан боловч гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь *"Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"* гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан *"Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"*-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган

төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төлбөр тооцоог хянаагүйгээс авлага үүсгэсэн.	1	304.7			1	304.7						
Төсвийг зориулалт бусаар зарцуулсан	1	225.0			1	225.0						
Дүн	2	529.7			2	529.7						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Нийт								